

Дотоод аудитын нэгж: Захиргаа удирдлагын хэлтсийн дарга бөгөөд дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ, тайлан мэдээ, программ хангамж, дотоод сүлжээ, хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

-ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН -

Аудитын нэр: Хүнс, хөдөө аж ахуй газрын 2015 оны төсөв болон аймгийн нөөц сангаас хуваарилсан хөрөнгийн зарцуулалт дотоод аудит үнэлэлт, дүгнэлт хийх

Жил: 2015 оны эхний хагас жил

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА : ХХААГазар
АУДИТ ХИЙГДСЭН ОБЪЕКТ: 2015 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан
АУДИТЫН ТӨРӨЛ : Нийцлийн аудит
АУДИТЫН ХУГАЦАА : 2015-08-10-наас 19-нийг дуустал ажлын 8 өдөр

Дотоод аудитын нэгж: Захиргаа удирдлагын хэлтсийн дарга бөгөөд дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ, тайлан мэдээ, программ хангамж, дотоод сүлжээ, хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ

1. ТАНИЛЦУУЛГА

Тус байгууллага нь аймгийн Засаг даргын 2005 оны 2 дугаар сарын 4-ний 42 дугаар захирамжаар 5.5 хүний орон тоотой байгуулагдсан 2009 оны 01 дүгээр сараас эхлэн 2008 оны ТУЗГ-ын 67 дугаар тогтоолын дагуу тус байгууллага шинэчлэгдэн зохион байгуулагдаж, ХХААЖДҮГазар нэртэйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж байгаад 2014 онд ҮХААГ, 2015 онд ХХААГ болж өөрчлөгдсөн.

Тус байгууллага нь Захиргаа удирдлагийн, Хүнс, газар тариалангийн, Мал эмнэлгийн болон Мал аж ахуйн гэсэн 4 хэлтэс 19 ажилтантай.

ХХААГ-ын үйл ажиллагааны стратеги нь Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, ЗГ, ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Хүнс, ХАА-н төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйлдвэр, хөдөө аж ахуйн талаархи бодлогын хэрэгжилтийг зохицуулж цаг үеэ олсон шуурхай мэдээлэл, бүх талаар дэмжлэг үзүүлэх юм.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Хүнс, хөдөө аж ахуй газрын 2015 оны төсөв болон аймгийн нөөц сангаас хуваарилсан хөрөнгийн зарцуулалт дотоод аудит үнэлэлт, дүгнэлт хийж газрын санхүүгийн эрсдлийг бууруулахад чиглэгдсэн болно.

2.2 Аудитын цар хүрээ

Хүнс, хөдөө аж ахуй газрын 2015 оны төсөв болон аймгийн нөөц сангаас хуваарилсан хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн биелэлтэд нийцлийн аудит хийх.

3. АУДИТЫН ҮР ДҮН

3.1. Илэрсэн асуудлууд

Асуудал 1.

Ариутгалын материалын худалдан авсан тухай санхүүгийн анхан шатны баримтуудын огноо зөрсөн, орлогод авсан нь баримтаар нотлогдохгүй байна.

Шалгуур : Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.-д “үнэн зөв байх;”, 9 дүгээр зүйлийн 9.1-д 9.1. “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох

бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Бодит нөхцөл байдал: Дорнын өглөө ХХК-ий 2012-02-02-ний нэхэмжлэлээр 2015-02-11-ний №17 тоот төлбөрийн хүсэлтээр Норматив зардлаас “Ариутгалын материалын үнэ” 158 мянган төгрөг шилжүүлсэн байна. Гэвч Хяналтын хуудас дахь Нэхэмжлэлийн огноог 2015-02-02 болгож өөрчилж, бичилт хийсэн. Мөн Орлого, зарлагын огноог 2015-02-02 гэж тусгасан боловч тус газрын Нярав Д.Баярмаагаас лавлахад ийм үнийн дүнтэй ариутгалын материал орлогод аваагүй гэж мэдэгдэв. Баримтад шүүж үзсэн боловч олдоогүй болно.

Шалтгаан: Хуурамч баримтаар гүйлгээ хийж, албан тушаалаа урвуулан ашигласан байж болзошгүй гэж үзэж байна.

Үр нөлөө: Уг зардлыг норматив зардлаас гаргаж санхүүжүүлсэн нь тус байгууллагын албан хаагчдын хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдалд тодорхой хэмжээнд сөрөгөөр нөлөөлж байна.

Асуудал 2.

Д.Хүрэлбаатар, Б.Лхагвасүрэнд олгосон тэтгэмжийг буруу тооцож олгосон

Шалгуур : Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “ДУНДАЖ ЦАЛИН ХӨЛС ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ”-ын 7.а-д “Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ажилтанд сул зогсолтын үеийн, ажил хүлээлцэх хугацааны, ажил, албан тушаал нь хэвээр хадгалагдаж байгаа үеийн, буруу халсан буюу шилжүүлсэн үеийн зөрүү, олговор олгох, нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл хөлс олгох, ажлын цагийг богиносгох, ажилтны хүсэлтээр ажилтанд тэтгэмжтэй чөлөө олгох, цалин хөлсний тодорхойлолт гаргах, ажилтанд ажлаас халагдсаны болон Хөдөлмөрийн тухай хуулийн 41.2-т заасны дагуу тэтгэмж олгох, ажилтанд эд хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлага хүлээлгэх, хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбогдуулан дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо тухайн ажилтны сүүлийн 3 сарын дундаж цалин хөлсөөр;” тооцно.

Бодит нөхцөл байдал: Тус газрын жижүүрээр ажиллаж байсан Д.Хүрэлбаатар, жижүүр, сантехникч, цахилгаанчнаар ажиллаж байсан Б.Лхагвасүрэн нарт ажлаас халагдсаны тэтгэмжийг тооцоходоо Д.Хүрэлбаатарт халагдахаас өмнөх 6 сар, Б.Лхагвасүрэнд 2 сарын үндсэн цалингийн нийлбэрээр бодож нийт 2958146 төгрөг тооцсон нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалыг зөрчиж байна.

Шалтгаан: Нягтлан бодогчийн ур чадвар, туршлага дутсан гэж үзэж байна.

Үр нөлөө: Дээд байгууллагуудаас гарсан тушаал шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байгаа байгууллагын нэр хүндэд муугаар нөлөөлөх, цаашлаад санхүүгийн сахилга батат сөргөөр нөлөөлнө гэж үзлээ.

Асуудал 3.

Амралтын цалинг буруу тооцож олгожээ

Шалгуур : Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 2 дугаар хавсралтын 7-д “Тухайн ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тодорхойлохдоо өмнөх ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тооцоход оруулсан хугацааны дундаж цалин хөлсийг давхардуулан оруулж тооцохгүй.Хэрэв өмнөх ажлын жилийн ээлжийн амралтын хөлсийг тооцоход

оруулсан саруудын дундаж цалин хөлс орохоор байвал уг хугацааг хасч, үлдсэ хугацааны дунджаар тооцно. Тухайлбал, 2000 оны 7 дугаар сарын 1-нээс амрах ажилтны ээлжийн амралтын олговрыг тооцох ажлын жил нь 1999 оны 7 дугаар сарын 1-нээс 2000 оны 7 дугаар сарын 1 хүртлэх хугацаа боловч, тэрээр өмнөх амралтаа 1999 оны 10 дугаар сард эдэлсэн бол түүний ээлжийн амралтаа эдэлж ажилдаа орсноос хойш (1999 оны 11 дүгээр сараас ажилдаа орсон гэж үзье) 2000 оны 7 дугаар сарын 1 хүртлэх хугацаанд ажилласан 8 сарын цалин хөлсний дунджаар тодорхойлно.” Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дугаар зүйлийн 79.5.-д “Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан үндсэн амралт дээр нь дор дурдсан нэмэгдэл амралт олгоно:”.

Бодит нөхцөл байдал: ЗУХэлтсийн дарга Б.Бат-Эрдэний амралтын цалинг тооцохдоо урьд онд амралттай байсан 2014-5 сарын цалинг оруулж тооцсон. Мөн 2014 оны 5, 6 сарын цалингуудыг сольж олгосноос цалингийн дундаж тооцоход зөрүү гарсан. Мөн С.Баасангийн цалингийн дундажийг тооцохдоо 2014-8 сараас 2015 оны 2 сар хүртэлх 7 сарын цалингийн нийлбэрээс тооцсон боловч дундажийг гаргахдаа 8 сард хувааж алдаа гаргасан байна. ЗУХэлтсийн дарга Б.Бат-Эрдэнэд 15 хоногийн амралтын цалинг олгох байсан боловч 18 хоногоор бодож амралтын мөнгийг илүү тооцсон. Цагийн бүртгэлээр 16 хоног амарсан байна.

Шалтгаан: Нягтлан бодогчийн ур чадвар, туршлага дутсан гэж үзэж байна.

Үр нөлөө: Дээд байгууллагуудаас гарсан тушаал шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байгаа байгууллагын нэр хүндэд муугаар нөлөөлөх, цаашлаад санхүүгийн сахилга батат сөргөөр нөлөөлнө гэж үзлээ.

Асуудал 4.

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, зарим зардлууд бодит гүйцэтгэлтэйгээ таарахгүй байна.

Шалгуур : Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.-д “үнэн зөв байх;”, 9 дүгээр зүйлийн 9.1-д 9.1. “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана.”, 13 дугаар зүйлийн “13.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Бодит нөхцөл байдал: Няравын шатахууны тайлангаар 2015-04 сард өссөн дүнгээр 1620500 төгрөг байгаа боловч төсвийн гүйцэтгэл мэдээнд 1400000 төгрөг гэж тайлагнасан байна. Мөн зарлагын баримтууд дутуу байв. Мөн үндсэн үйл ажиллагааны орлого 239600 төгрөг байтал төсвийн гүйцэтгэлийн мэдээнд 189600 төгрөг гэж тайлагнажээ. Үүний шалтгаан нь Дархан нэхий ХК-ий 50000 төгрөгийн орлогыг буруу дансанд авсан байна.

2014 оны 12 сард хийгдсэн Мандах он ХХК, Ветмон ХХК-иуд нь Малд ялган тэмдэглээ хийсэн баримт дээрээ Малчин өрхийн баталгааны тэмдэгийг даруулаагүй байсан тул цаашид анхаарах.

Шалтгаан: Нягтлан бодогчийн ур чадвар, туршлага дутсан гэж үзэж байна.

Үр нөлөө: Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал алдагдах, цаашлаад санхүүгийн сахилга батат сөргөөр нөлөөлнө гэж үзлээ.

3.2. Нэгдсэн дүгнэлт

Хүнс, хөдөө аж ахуй газрын 2015 оны төсөв болон аймгийн нөөц сангаас хуваарилсан хөрөнгийн зарцуулалт дотоод аудит үнэлэлт, дүгнэлт хийхэд ажилчдад болон ажиллагсдад олгох цалин, тэтгэмжийг тооцоолохдоо тооцоо алдах, холбогдох дээд байгууллагын шийдвэрүүдийг

хэрэгжүүлэхгүй байх, санхүү анхан шатны баримтууд бүрдэл дутуу, хангалтгүй байх зэрэг нийтлэг алдаа дутагдлууд байна. Санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн зөрчил, эрсдлийг бууруулах чиглэлээр удирдлагын зүгээс тогтмол хяналт тавиж ажиллах.

3.3. Зөвлөмж

Аудитын дүн дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжүүдийг өгч байна.

- Дорнын өглөө ХХК-ий 2012-02-02-ний нэхэмжлэлээр 2015-02-11-ний №17 тоот төлбөрийн хүсэлтээр Норматив зардлаас “Ариутгалын материалын үнэ” 158 мянган төгрөг шилжүүлснийг нарийвчлан тодруулж эргэн тайлагнах.
- Д.Хүрэлбаатард дутуу олгосон 18065 төгрөгийг нөхөж олгох
- Б.Бат-Эрдэнэд илүү олгосон 12767 төгрөгийг цалингаас суутгах, С.Баасанд дутуу олгосон 73884 төгрөгийн амралтын цалинг тооцож олгох.
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хангалтгүй байгаад анхаарал хандуулж санхүүгийн сахилга батыг сайжруулах.
- Мал эмнэлэг, үржлийн нэгжүүдийн санхүү анхан шатны баримтуудад Малчин өрхийн баталгааны тэмдэгийг заавал дарсан байх шаардлагыг тавьж ажиллах, Малчдад “Малчин өрхийн баталгааны тэмдэг”-ээ хэрхэн хэрэглэх ашиглах талаар мэдээлэл, сурталчилгаа хийх.
- Газрын дарга нь аливаа нэг санхүүгийн баримтыг баталгаажуулахдаа нарийвчлан тодруулж, нэг дор олон баримтад баталгаажуулалтыг хийхээс аль болох зайлс хийх.

Тайлан гаргасан:

Захиргаа удирдлагын хэлтсийн дарга бөгөөд дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ, тайлан мэдээ, программ хангамж, дотоод сүлжээ, хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

Б.Бат-Эрдэнэ

Танилцсан:

ХХААГ-ын Дарга

Ц.Энхжаргал

Нягтлан бодогч

Ц.Энхсайхан